

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газрын 2023 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/54-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="#">www.audit.mn</a> Сүхбаатар сум 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: <a href="#">enkhtuyach@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: <a href="#">batmunkhb@audit.gov.mn</a> Аудитор: Ц.Ундраа Утас: 70362442 Цахим хаяг: <a href="#">undraats@audit.gov.mn</a>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна  
уу.

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ.....	3-4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал .....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.5.1 Завсрын аудитын талаар .....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	19
5.2 Албан шаардлага .....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	22

#### Товчилсон үгийн жагсаалт

<b>АДБОУС</b>	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
<b>БОАЖГ</b>	Байгаль орчин аялал жуулчлалын газар
<b>БОАЖС</b>	Байгаль орчин аялал жуулчлалын сайд
<b>ЗГ</b>	Засгийн газар
<b>ЗДТГ</b>	Засаг даргын Тамгын газар
<b>ИТХ</b>	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
<b>САЗД</b>	Сэлэнгэ аймгийн Засаг дарга
<b>ТЕЗ</b>	Төсвийн ерөнхийлөн захирагч
<b>ХНХС</b>	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
<b>ХХК</b>	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
<b>УСНББОУС</b>	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА  
З.ТҮВШИНТӨГС ТАНАА**

2024.02.23 № СЭА-2024/54-НА-СЭА-113  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоол болон төрийн захиргааны албан хаагчдад үндсэн цалингийн 50.0 хувиар тооцож орон нутгийн нэмэгдэл олгох, үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээг 40.0 хувиар нэмэгдүүлэх тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 80 дугаар тогтоолуудыг тус тус хэрэгжүүлэн цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардалд 1,096,813,2 мянган төгрөг зарцуулсан нь өмнөх оноос 2.1 дахин өссөн байна.

## **Аудитын гол асуудал**

Үндсэн үйл ажиллагааны шатахуун, албан томилолтын зардлаас гадна Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд “байгаль хамгаалах чиглэлийн хяналт хэрэгжүүлэх” гэсэн ангилалд 50,000.0 мянган төгрөгийг төлөвлөж, албан томилолт, шатахуунд зарцуулсан байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>20,144,433.00</b>	<b>22,773,183.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>20,144,433.00</b>	<b>22,773,183.00</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>1,500,000.00</b>	<b>1,500,000.00</b>
<b>35110</b>	Тусгай зориулалттай материал	1,500,000.00	1,500,000.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>18,644,433.00</b>	<b>21,273,183.00</b>
<b>35410</b>	Бичиг хэргийн материал	2,193,000.00	3,550,350.00
<b>35420</b>	Аж ахуйн материал	841,000.00	2,271,250.00
<b>35440</b>	Түлш, шатах тослох материал	610,000.00	451,150.00
<b>35470</b>	Бусад хангамжийн материал	15,000,433.00	15,000,433.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>150,889,617.46</b>	<b>240,093,403.94</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>150,889,617.46</b>	<b>240,093,403.94</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>98,033,463.13</b>	<b>196,686,753.73</b>
<b>39201</b>	Барилга, байгууламж, орон сууц	5,838,740.00	5,838,740.00
<b>39202</b>	Хуримтлагдсан элэгдэл	-3,127,896.45	-3,962,002.17
<b>39203</b>	Авто-тээврийн хэрэгсэл	55,950,000.00	55,950,000.00
<b>39204</b>	Хуримтлагдсан элэгдэл	-19,362,500.19	-28,687,500.27
<b>39205</b>	Машин тоног төхөөрөмж(компьютер)	70,010,685.00	162,707,120.88
<b>39206</b>	Хуримтлагдсан элэгдэл	-37,236,722.15	-64,145,873.12
<b>39207</b>	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,601,070.00	83,492,849.88
<b>39208</b>	Хуримтлагдсан элэгдэл	-11,221,331.83	-22,722,925.22
<b>39214</b>	Бусад үндсэн хөрөнгө	21,600,300.00	21,600,300.00
<b>39215</b>	Хуримтлагдсан элэгдэл	-9,018,881.25	-13,383,956.25
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>52,856,154.33</b>	<b>43,406,650.21</b>
<b>39301</b>	Програм хангамж	65,147,600.00	65,147,600.00
<b>39302</b>	Хуримтлагдсан элэгдэл	-12,491,445.67	-21,940,949.79
<b>39303</b>	Бусад биет бус хөрөнгө	200,000.00	200,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>171,034,050.46</b>	<b>262,866,586.94</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>171,034,050.46</b>	<b>262,866,586.94</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>171,034,050.46</b>	<b>262,866,586.94</b>
<b>51100</b>	Засгийн газрын оруулсан капитал	121,834,119.85	121,834,119.85
<b>511002</b>	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	121,834,119.85	121,834,119.85
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>47,814,707.49</b>	<b>139,647,243.97</b>
<b>51210</b>	Өмнөх үеийн үр дүн	160,644,094.02	47,814,707.49
<b>51220</b>	Тайлант үеийн үр дүн	-112,829,386.53	91,832,536.48
<b>51300</b>	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,385,223.12	1,385,223.12
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>171,034,050.46</b>	<b>262,866,586.94</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,138,555,512.18</b>	<b>3,201,279,800.05</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>75,480,073.00</b>	<b>35,007,366.54</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>75,480,073.00</b>	<b>35,007,366.54</b>

120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	74,970,073.00	34,277,366.54
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	510,000.00	730,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,063,075,439.18</b>	<b>3,166,272,433.51</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>19,902,576.00</b>	<b>13,382,201.00</b>
131103	ЗГНХ,ЗДН Хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	13,382,201.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>2,043,172,863.18</b>	<b>3,152,890,232.51</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,043,172,863.18	3,152,890,232.51
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,056,359,106.92</b>	<b>3,109,447,263.57</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,056,359,106.92</b>	<b>3,109,447,263.57</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,049,872,592.92</b>	<b>3,075,140,403.57</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>529,302,255.00</b>	<b>1,096,813,193.15</b>
210101	Үндсэн цалин	422,773,847.00	597,052,232.73
210102	Нэмэгдэл	59,599,066.00	332,468,023.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,895,000.00	76,949,160.54
210104	Урамшуулал	23,034,342.00	90,343,776.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>66,916,944.18</b>	<b>136,720,902.93</b>
210201	Тэтгэврийн даатгал	46,393,118.34	94,280,717.12
210202	Тэтгэмжийн даатгал	5,465,990.05	11,077,614.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,241,752.39	8,787,288.54
210204	Ажилгүйдлийн даатгал	983,279.43	2,057,585.03
210205	Эрүүл мэндийн даатгал	9,832,803.97	20,517,698.07
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>0</b>	<b>31,680,937.36</b>
210301	Гэрэл, цахилгаан	0	768,959.36
210302	Түлш, халаалт	0	30,527,198.00
210303	Цэвэр, бохир ус	0	384,780.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>43,013,654.00</b>	<b>32,353,912.07</b>
210401	Бичиг хэрэг	3,883,850.00	5,096,150.00
210402	Тээвэр, шатахуун	23,185,139.00	15,700,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,271,710.00	1,335,462.07
210404	Ном, хэвлэл	3,684,000.00	84,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,988,955.00	10,138,300.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,938,800.00</b>	<b>49,974,500.00</b>
210604	Урсгал засвар	8,938,800.00	49,974,500.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>11,342,300.00</b>	<b>17,971,300.00</b>
210702	Дотоод албан томилолт	11,342,300.00	17,971,300.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>21,824,550.00</b>	<b>11,193,685.00</b>

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,100.00	100,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	297,450.00	200,925.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	470,200.00	140,860.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	20,743,000.00	10,596,700.00
210807	Газрын төлбөр	168,800.00	100,200.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,368,534,089.74</b>	<b>1,698,431,973.06</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,328,067,607.00	1,653,293,203.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	210,000.00	210,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	40,256,482.74	44,928,770.06
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,486,514.00</b>	<b>34,306,860.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>6,486,514.00</b>	<b>34,209,260.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	21,408,960.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	12,800,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0	97,600.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0	97,600.00
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>82,196,405.26</b>	<b>91,832,536.48</b>
VI	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-112,829,386.53</b>	<b>91,832,536.48</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,143,075,439.18</b>	<b>3,166,272,433.51</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,143,075,439.18</b>	<b>3,166,272,433.51</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	99,902,576.00	13,382,201.00
131103	ЗГНХ,ЗДН Хөрөнгө,түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	13,382,201.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>2,043,172,863.18</b>	<b>3,152,890,232.51</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,043,172,863.18	3,152,890,232.51
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,118,355,354.18</b>	<b>3,066,417,243.51</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,118,355,354.18</b>	<b>3,066,417,243.51</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,111,868,840.18</b>	<b>3,032,110,383.51</b>

<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>529,302,253.37</b>	<b>1,096,813,193.15</b>
210101	Үндсэн цалин	423,519,642.58	597,052,232.73
210102	Нэмэгдэл	58,853,268.79	332,468,023.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,895,000.00	76,949,160.54
210104	Урамшуулал	23,034,342.00	90,343,776.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>66,916,945.81</b>	<b>136,720,902.93</b>
210201	Тэтгэврийн даатгал	46,409,919.97	94,280,717.12
210202	Тэтгэмжийн даатгал	5,449,190.05	11,077,614.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,241,752.39	8,787,288.54
210204	Ажилгүйдлийн даатгал	983,279.43	2,057,585.03
210205	Эрүүл мэндийн даатгал	9,832,803.97	20,517,698.07
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>0</b>	<b>31,680,937.36</b>
210301	Гэрэл, цахилгаан	0	768,959.36
210302	Түлш, халаалт	0	30,527,198.00
210303	Цэвэр, бохир ус	0	384,780.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16,650,465.00</b>	<b>32,254,012.07</b>
210401	Бичиг хэрэг	2,727,100.00	5,096,150.00
210402	Тээвэр, шатахуун	10,900,000.00	15,700,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,271,710.00	1,335,462.07
210404	Ном, хэвлэл	84,000.00	84,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,667,655.00	10,038,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,000,000.00</b>	<b>49,974,240.00</b>
210604	Урсгал засвар	8,000,000.00	49,974,240.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,228,900.00</b>	<b>17,971,300.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,228,900.00	17,971,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,544,550.00</b>	<b>11,193,685.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,100.00	100,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	297,450.00	200,925.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	470,200.00	140,860.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	463,000.00	10,596,700.00
210807	Газрын төлбөр	168,800.00	100,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,484,225,726.00</b>	<b>1,655,502,113.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,484,015,726.00	1,655,292,113.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	210,000.00	210,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,486,514.00</b>	<b>34,306,860.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,486,514.00	34,209,260.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	21,408,960.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,486,514.00	12,800,300.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0	97,600.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0	97,600.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	24,720,085.00	99,855,190.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	24,720,085.00	99,855,190.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	24,720,085.00	99,855,190.00
2200	Дотоод эх үүсвэрээр	24,720,085.00	99,855,190.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	24,720,085.00	99,855,190.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-24,720,085.00	-99,855,190.00

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	121,834,119.85	1,385,223.12	160,644,094.02	283,863,436.99
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	121,834,119.85	1,385,223.12	160,644,094.02	283,863,436.99
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-112,829,386.53	-
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	121,834,119.85	1,385,223.12	47,814,707.49	112,829,386.53
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	121,834,119.85	1,385,223.12	47,814,707.49	171,034,050.46
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	121,834,119.85	1,385,223.12	47,814,707.49	171,034,050.46
19	Тайлант үеийн үр дүн	0	0	91,832,536.48	91,832,536.48
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	121,834,119.85	1,385,223.12	139,647,243.97	262,866,586.94

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,271,746,300.00	3,152,890,232.51	118,856,067.49	96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,271,746,300.00	3,152,890,232.51	118,856,067.49	96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,203,056,900.00	3,118,680,972.51	84,375,927.49	97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,120,331,100.00	1,096,813,193.15	23,517,906.85	98
210101	Үндсэн цалин	627,927,400.00	597,052,232.73	30,875,167.27	95
210102	Нэмэгдэл	340,507,000.00	332,468,023.88	8,038,976.12	98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	85,982,100.00	76,949,160.54	9,032,939.46	89

210104	Урамшуулал	65,914,600.00	90,343,776.00	-24,429,176.00	137
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>161,066,400.00</b>	<b>136,720,902.93</b>	<b>24,345,497.07</b>	<b>85</b>
210201	Тэтгэврийн даатгал	109,525,200.00	94,280,717.12	15,244,482.88	86
210202	Тэтгэмжийн даатгал	12,885,300.00	11,077,614.17	1,807,685.83	86
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,308,200.00	8,787,288.54	1,520,911.46	85
210204	Ажилгүйдлийн даатгал	2,577,100.00	2,057,585.03	519,514.97	80
210205	Эрүүл мэндийн даатгал	25,770,600.00	20,517,698.07	5,252,901.93	80
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>45,020,800.00</b>	<b>31,680,937.36</b>	<b>13,339,862.64</b>	<b>70</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,318,300.00	768,959.36	3,549,340.64	18
210302	Түлш, халаалт	39,012,500.00	30,527,198.00	8,485,302.00	78
210303	Цэвэр, бохир ус	1,690,000.00	384,780.00	1,305,220.00	23
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>32,354,400.00</b>	<b>32,353,912.07</b>	<b>487.93</b>	<b>100</b>
210401	Бичиг хэрэг	5,000,000.00	5,096,150.00	-96,150.00	102
210402	Тээвэр, шатахуун	17,570,400.00	15,700,000.00	1,870,400.00	89
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,200,000.00	1,335,462.07	-135,462.07	111
210404	Ном, хэвлэл	84,000.00	84,000.00	0.00	100
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,500,000.00	10,138,300.00	-1,638,300.00	119
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>150,000,000.00</b>	<b>149,729,530.00</b>	<b>270,470.00</b>	<b>100</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	60,000,000.00	59,923,490.00	76,510.00	100
210602	Тавилга	40,000,000.00	39,831,800.00	168,200.00	100
210604	Урсгал засвар	50,000,000.00	49,974,240.00	25,760.00	100
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>18,000,000.00</b>	<b>17,971,300.00</b>	<b>28,700.00</b>	<b>100</b>
210702	Дотоод албан томилолт	18,000,000.00	17,971,300.00	28,700.00	100
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>11,574,200.00</b>	<b>11,193,685.00</b>	<b>380,515.00</b>	<b>97</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	200,000.00	100,000.00	100,000.00	50
210803	Даатгалын үйлчилгээ	201,000.00	200,925.00	75.00	100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	141,000.00	140,860.00	140.00	100
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00	0.00	100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,703,000.00	10,596,700.00	106,300.00	99
210807	Газрын төлбөр	117,500.00	100,200.00	17,300.00	85
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,664,710,000.00</b>	<b>1,642,217,512.00</b>	<b>22,492,488.00</b>	<b>99</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,664,500,000.00	1,642,007,512.00	22,492,488.00	99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	210,000.00	210,000.00	0.00	100
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>68,689,400.00</b>	<b>34,209,260.00</b>	<b>34,480,140.00</b>	<b>50</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	68,689,400.00	34,209,260.00	34,480,140.00	50
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	54,689,400.00	21,408,960.00	33,280,440.00	39

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,000,000.00	12,800,300.00	1,199,700.00	91
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,271,746,300.00</b>	<b>3,152,890,232.51</b>	<b>118,856,067.49</b>	<b>96</b>
32	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,271,746,300.00</b>	<b>3,152,890,232.51</b>	<b>118,856,067.49</b>	<b>96</b>
320001	Орон нутгийн төсвөөс	3,271,746,300.00	3,152,890,232.51	118,856,067.49	96
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>117</b>	<b>105</b>	<b>12.00</b>	
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0.00</b>	
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	
62	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>58</b>	<b>52</b>	<b>6.00</b>	
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	
620002	Гүйцэтгэх ажилтан	55	49	6.00	
620003	Үйлчлэх ажилтан	2	2	0.00	
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>58</b>	<b>52</b>	<b>6.00</b>	
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	53	42	11.00	
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	10	-5.00	

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

				/төгрөгөөр/	
№	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	Зөрүү	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>13,382,201.00</b>	<b>-13,382,201.00</b>	
3	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>13,382,201.00</b>	<b>-13,382,201.00</b>	
4	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		13,382,201.00	-13,382,201.00	
5	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>			-13,382,201.00	
6	Бараа үйлчилгээний бусад зардал		13,382,201.00	-13,382,201.00	
7	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		97,600.00	-97,600.00	
8	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>			-13,382,201.00	
9	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		13,382,201.00	-13,382,201.00	
10	ЗГНХ,ЗДН Хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		13,382,201.00	-13,382,201.00	
11	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>				
12	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
13	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар /цаашид (Сэлэнгэ аймгийн БОАЖГ гэх) нь *“Байгаль орчин, аялал жуулчлал, ногоон хөгжлийн хууль тогтоомжуудыг харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, ногоон хөгжлийг дэлгэрүүлэх замаар байгаль орчны тэнцлийг хангаж, хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад оршино”* гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгаль орчны багц хууль тогтоомжийг харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх,
- Байгаль орчны мэдээллийн сан бүрдүүлэх, аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх, ногоон хөгжлийг дэлгэрүүлэх,
- Байгаль орчны сургалт, сурталчилгааны ажлыг гүйцэтгэх үйл ажиллагааг явуулах,
- Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх,
- Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангах,
- Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах гэх мэт.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Үүнд:

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт,*

БОАЖГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын алба, ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсээс сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсвийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ аймгийн БОАЖГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн БОАЖГ нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын хэмжээнд дагаж мөрдөгдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг бус тус газрын даргын 2018 оны А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байна.

Цаашид бүртгэлийн үйл ажиллагаанд Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын хэмжээнд дагаж мөрдөгдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөх нь зүйтэй юм.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Сэлэнгэ аймгийн БОАЖГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 91,832.53 мянган төгрөгөөр буюу 53.69 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага		-	
Бараа материал	20,144.43	22,773.18	2,628.75
Үндсэн хөрөнгө	150,889.62	240,093.40	89,203.78
Нийт хөрөнгө	<b>171,034.05</b>	<b>262,866.58</b>	<b>91,832.53</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	171,034.05	262,866.58	91,832.53
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<b>171,034.05</b>	<b>262,866.58</b>	<b>91,832.53</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 240,093.40 мянган төгрөг болж 89,203.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 99,855.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан, татан буугдсан мэргэжлийн хяналтын байгууллагаас 51,733,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж болон тавилга үнэ төлбөргүйгээр хүлээн авсан болон 62,384.4 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 262,866.5 мянган төгрөг болж 91,832.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс үндсэн үйл ажиллагааны зардалд 1,113,984.0 мянган төгрөг, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 1,664,500.0 мянган төгрөг зэрэг нийт зарлагыг 2,778,484.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин, НДШ-ийн зардлыг 233,614.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, бараа ажил үйлчилгээний зардлыг 185,414.2 мянган төгрөгөөр бууруулж, төсвийн үндсэн үйл ажиллагааны зардал 1,102,495.1 мянган төгрөг, байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардалд 1,664,500.0 мянган төгрөг, нийт төсвийг 2,826,684.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн дундуур ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 141 дүгээр тогтоолоор төсөвт тодотгол хийж 445,061.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 3,271,746.3 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин, НДШ-ийн зардлыг 381,099.9 мянган төгрөг,

- Байр ашиглалттай холбоотой зардлыг 45,020.3 мянган төгрөг,
- Хангамж бараа материалын зардлыг 5,599.7 мянган төгрөг,
- Эд хогшил, урсгал засварын зардал 10,000.0 мянган төгрөг,
- Томилолт, зочны зардлыг 3,342.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,271,746.3 мянган төгрөгийн төсөв баталж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр **3,152,890.2** мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **3,152,890.2** мянган төгрөг буюу 96.3 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 23,517.9 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 24,345.5 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлыг 13,339.9 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 34,480.1 мянган төгрөгөөр, байгаль хамгаалах нөхөн сэргээх хөтөлбөрийн зардлыг 22,492.5 мянган төгрөгөөр гэх мэт нийт батлагдсан төсвийг **118,856.1** мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

		/мянган төгрөгөөр/				
д/д	Хөтөлбөр,	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувь
1	71413- Байгаль орчин хамгаалан нөхөн сэргээх	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	1,493,536.1	1,444,992.5	48,543.6	96.7
2		80111-Барилгын тогтмол зардал	45,020.8	31,680.9	13,339.9	70.3
3		80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	68,689.4	34,209.3	34,480.1	49.8
4		81701-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	1,664,500.0	1,642,007.5	22,492.5	98.6
		<b>Нийт</b>	<b>3,271,746.3</b>	<b>3,152,890.2</b>	<b>118,856.1</b>	<b>96.3</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2023 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн А/230 дугаар захирамжийн дагуу “Тэр бум мод-Ногоон хөгжил”-ийн салбарын зөвлөгөөн, өдөрлөг, үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ажлыг санхүүжүүлэхэд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 13,382.2 мянган төгрөгийн

санхүүжилт олгосныг 13,284.6 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж 97.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагаа

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдаж, батлагдсан шууд худалдан авах босго үнээс давсан 10 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг аймгийн ОНӨГ-аар зохион байгуулуулсан байна.

Үүнээс 4 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 6 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулах зарыг TENDER.MN цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. Үүнд:

д/д	Төсөл, арга хэмжээ	Төсөвт өртөг / мян төг /	Гэрээний үнэ / мян төг /	Сонгон шалгарсан аж ахуйн нэгжийн нэр
1	Хомсдол, доройтолд орсон ойд ойжуулалтын ажлыг гүйцэтгүүлэх	240,000.0	231,664.0	Ойн хүрэм ХХК 207664.0, Бугант минж ХХК 24000.0
2	Хамгаалалтын ойн зурвас байгуулах	225,000.0	222,032.0	Ойн хүрэм ХХК 55632.0, 56000.0, Тэнгэрлэг ой ХХК 55200.0, 55200.0
3	Ойн хөнөөлт шавжийн тэмцлийн ажлыг онгоц, үүргийн шүршигч ашиглан гүйцэтгүүлэх	357,600.0	357,037.8	Мөнх ногоон жодоо ХХК
4	Хөв цөөрөм байгуулах	191,650.0	184,507.5	Эрчимт Сэлэнгэ өрнөл ХХК
5	Аймгийн хэмжээнд агнуур зохион байгуулалтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	50,000.0	48,324.02	Монголын анчдын нийгэмлэг
6	Сибирь хуш, сибирь жодоо, сибирь гацуур зэрэг ховор зүйлийн модны тарьцаар ойжуулалтын ажлыг хийх	60,000.0	60,000.0	Бугант минж ХХК
7	Голын эрэг орчмыг бургасжуулах	56,250.0	56,024.46	Модны эмч ХХК
8	Боргоцойн цех байгуулах / зураг төслийн хамт /	80,000.0	79,749.29	Залуу төгөл ХХК
9	Ой цэвэрлэх ажлын хүрээнд ойгоос гарах хаягдлыг дахин боловсруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах	80,000.0	79,796.40	Интервүүд ХХК
10	Сайхан, Орхон сумдад байгуулсан хамгаалалтын ойн зурвасын усалгааны эх үүсвэрийг шийдэх	60,000.0	60,000.00	Сэлэнгэ Ундрэм ХХК
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>1,400,500.0</b>	<b>1,379,135.47</b>	

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

---

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу БОАЖГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Ундраа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

БОАЖГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 56 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,043,172.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 20,431.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор тус байгууллага нь бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлж шуудан холбооны зардлыг хэмнэсэн, шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй, байгууллагын гэрэл, цахилгааны хэрэглээг хэмнэсэн зэргээр төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, баталсан төсвийн хүрээнд ил тод байдлыг ханган ажилласан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 23,517.9 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 24,345.5 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 270.5 мянган төгрөгөөр, томилолт зочны зардлыг 28.7 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 380.5 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлыг 13,339.8 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 34,480.7 мянган төгрөгөөр, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг 22,492.5 мянган

төгрөгөөр зэрэг нийт 118,856.1 мянган төгрөгийн хэмнэлттэй тайлагнагдсан байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд БОАЖГ нь мэдээлбэл зохих 28 төрлийн 159 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус газрын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 548.9 мянган төгрөгийн акт, 1,998.7 мянган төгрөгийн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж тайлант онд давтан гаргаагүй ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган  
төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	548.9	1	548.9	100.0
Зөвлөмж	1	1,998.7	1	1,998.7	100.0
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>1,998.7</b>	<b>1</b>	<b>1,998.7</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарах асуудал байхгүй болно.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт **93,402.2** мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Үнэ төлбөргүй шилжиж ирсэн 35,007.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалыг санхүүгийн үр дүнгийн тайланд орлогоор бүртгэхдээ ангиллыг буруу сонгосон,
- Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлсэн шатахуун, албан томилолтын 54,929.8 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны шатахуун томилолтын зардалд тайлагнасан,
- 2023 онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан үндсэн хөрөнгийн 3,465.0 мянган төгрөгийн элэгдэл дутуу тайлагнасан байна.

Аудитаар нийт **10,134.1** мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс **4,805.6** мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **5,328.5** мянган төгрөгийн албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлэв.

##### 5.1 Төлбөрийн акт:

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний эх үүсвэрээр хийгдэх “Хөв цөөрөм байгуулах” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр шалгарсан Сэлэнгэ ундрам компанид дараах зориулалтын нийт **4,805.6** мянган төгрөгийг илүү шилжүүлсэн байна. Үүнд:

- Техник хяналтын зардал- 3,203.8 мянган төгрөг,
- Зохиогчийн хяналтын зардал-1,601.8 мянган төгрөг.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага, төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар, илүү шилжүүлсэн санхүүжилтийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 5.2 Албан шаардлага

5.2.1 Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний батлагдсан төсвөөс үндсэн үйл ажиллагааны зардалд зориулалт бусаар 3,008.5 мянган төгрөг зарцуулсан боловч гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Үүнд:

- Улсын байцаагч Л.Хишигсүрэн, жолооч О.Мягмар нарт 600.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж урамшуулал олгосон,
- Мон өртөөчин ХХК-д маягт хэвлүүлсний төлбөрт 2,408.5 мянган төгрөг шилжүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтуудыг болон Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан “*Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал*”, 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “*Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар*”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, санхүүгийн тайланг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв илэрхийлж байх албан шаардлага хүргүүлэх.

5.2.2 Ерөө сумын Толгойтын давааны Хяналтын постод ажилласан албан хаагчдад хоолны зардлаас гадна байрны зардлыг хоногийн 40.0 мянган төгрөгөөр тооцож, 2,320.0 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүб.4.1 дэх “*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага, төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулж байх албан шаардлага хүргүүлэх.

## 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал:

1.1.Илрүүлэлт: Үнэ, өртгийн тооцоо судалгаа, төсөв нь урьдчилан хийгдээгүй төсөл, арга хэмжээнүүдийг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр аймгийн ИТХ-аар батлуулж, хэрэгжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “*Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална: “5.1.2: Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Төсөл, арга хэмжээний үнэ өртөг, төсвийн тооцооллыг урьдчилан хийсний үндсэн дээр аймгийн ИТХ-аар батлуулж, хэрэгжүүлж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>3</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>3</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийн элэгдэл дутуу тайлагнасан	1	3,465.0			1	3,465.0	1	3,465.0				
Дансны ангилал буруу тайлагнасан	1	35,007.4			1	35,007.4	1	35,007.4				
Байгаль орчин хамгаалах нөхөн сэргээх зардлын томилолт шатахууны зардлыг үндсэн үйл ажиллагааны зардалд тайлагнасан	1	54,929.8			1	54,929.8	1	54,929.8				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>93,402.2</b>			<b>1</b>	<b>93,402.2</b>	<b>1</b>	<b>93,402.2</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Гүйцэтгэгчид илүү санхүүжилт олгосон.	1	4,805.6	1	4,805.6								
Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан	1	3,008.5			1	3,008.5						
Төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан	1	2,320.0			1	2,320.0						
Үнэ, өртгийн судалгаа, төсөв хийгдээгүй төсөл, арга хэмжээг БХНСАХ-ний зардалд төлөвлөж хэрэгжүүлсэн	1						1					
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>10,134.1</b>	<b>1</b>	<b>4,805.6</b>	<b>2</b>	<b>5,328.5</b>	<b>1</b>					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
<b>Дүн</b>								